



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн нийцлийн аудитын тайлан



Сонгуулийн зардлын тайланг 2 нам, 3 нэр дэвшигч ирүүлээгүй, тайлан ирүүлсэн нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг хуулийн дагуу зарцуулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 03

Улаангом

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9, 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А/102 дугаар “Эрх шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх” сэдэвт нийцлийн аудитын тайланг /ГНАГ-2024/12-ШТА-НА-УВА/ хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Татварын газарт тус тус хүргүүлсүгэй.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер М.Бат-Амгалан, ахлах аудитор Б.Авирмэд нарт даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ

Тайлан бэлтгэсэн:	Агуулга	3
Дарга, тэргүүлэх аудитор	Товчилсон үгийн тайлал	4
М.Батсуурь	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5
Аудитын менежер	Ерөнхий мэдээлэл	6
М.Бат-Амгалан	Бүлэг 1. Орон нутгийн ИТХ-ын сонгуульд оролцсон	7
Ахлах аудитор	2 нам, 13 нэр дэвшигчдээс бусад нь Аймаг	7
Б.Авирмэд	нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн	7
Аудитор	хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэн	7
Р.Аюуш	ажилласан байна.	7
2025 оны 01 дүгээр сар	1.1. Орон нутгийн сонгуульд оролцсон 1 нам, 9 нэр	7
Аудитын тайлан, дүгнэлттэй	дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны	7
холбоотой асуудлаар нэмж	нэрийг бүртгүүлээгүй байна.	7
тодруулах, асууж лавлах зүйл	1.2. Сонгуулийн зардлын тайланг 2 нам 3 нэр дэвшигч	7
байвал 7045-3317 дугаарын	гаргаж ирүүлээгүй байна.	7
утсаар харилцана уу.	1.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн	7
Хаяг:	төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 53	7
Увс аймаг дахь Төрийн	дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт заасан хандивын	7
аудитын газар, Улаангом сум	хэмжээг хэтрүүлээгүй байна.	7
3 дугаар баг, аймгийн Засаг	1.4 Сонгуулийн зардлын данс байршуулсан банк	8
даргын тамгын газрын байр	сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс	8
304 тоот	хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн	8
Хаяг:	дансны гүйлгээний мэдээллийг ирүүлсэн байна.	8
Увс аймаг дахь Төрийн	Бүлэг 2. Сонгуулийн зардлын дансанд	9
аудитын газар, Улаангом сум	төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг 16 нэр дэвшигчээс	9
3 дугаар баг, аймгийн Засаг	бусад нь хуульд заасан зориулалтын дагуу	9
даргын тамгын газрын байр	зарцуулсан байна.	9
304 тоот	2.1. Нийт 16 нэр дэвшигч хуульд заасан шаардлагыг	9
Хаяг:	хангаагүй хандивыг зарцуулсан байна.	9
Увс аймаг дахь Төрийн	2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн	9
аудитын газар, Улаангом сум	төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 55	9
3 дугаар баг, аймгийн Засаг	дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан хандив өгөхийг	9
даргын тамгын газрын байр	хориглосон этгээдээс хандив хүлээн аваагүй байна.	9
304 тоот	2.3. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр	9
Хаяг:	дэвшигчид сонгуулийн зардлыг журмын дагуу	9
Увс аймаг дахь Төрийн	зарцуулж, тайлагнасан байна.	9
аудитын газар, Улаангом сум	Бүлэг 3. Сонгуулийн тойрогт нэр дэвшигч, нам	11
3 дугаар баг, аймгийн Засаг	эвсэл нь сонгуульд зарцуулах зардлын дээд	11
даргын тамгын газрын байр	хэмжээг хэтрүүлээгүй байна.	11
304 тоот	3.1. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр	11
Хаяг:	дэвшигчид сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг	11
Увс аймаг дахь Төрийн	хэтрүүлээгүй байна.	11
аудитын газар, Улаангом сум	3.2. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр	13
3 дугаар баг, аймгийн Засаг	дэвшигчид мөнгөн бус хандив аваагүй байна.	13
даргын тамгын газрын байр	Дүгнэлт	14
304 тоот	Зөвлөмж	15

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

Товчилсон үгийн тайлал:

Д/д	Товчлол	Товчилсон үгийн тайлбар
1	ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
2	АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
3	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
4	НА	Нийцлийн аудит

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 8 дугаар тогтоол, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/152 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийлээ.

Аудитын зорилт

Орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланг хянан баталгаажуулж дүгнэлт гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, иргэдэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчид Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиар хориглосон хандив авсан эсэх.
- Сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан эсэх.

Хамарсан хүрээ

Аудитад Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан болон холбогдох баримт материалыг хамруулав.

Арга зүй

Аудитыг АДБОУС 100, 400, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын журмыг баримтлан, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторовын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/26 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам"-ыг үндэслэн нам, эвслээс оруулсан хөрөнгө, иргэн, хуулийн этгээдээс авсан хандив түүний зарцуулалтын тайланг шалгаж, аудит хийсэн хуулийн этгээд, нам, эвслээс лавлагаа, тодруулга авч, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж тайланг бэлтгэв.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Нийцлийн аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулж, ахлах аудитор Б.Авирмэд, аудитор Р.Аюуш нар

2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд нийт 923 нэр дэвшигч оролцсон ба аймаг, сумын ИТХ-д 7 нэр дэвшигч давхар нэр дэвшсэн байна. Үүнд:

/Хүснэгт 1/

Намын нэр	Нам	Нэр дэвшигчид
Монгол ардын нам	1	431
Ардчилсан нам	1	431
Иргэний зориг ногоон нам	1	7
Иргэний хөдөлгөөний нам	1	4
Бие даагч		50
Нийт	4	923

Эх сурвалж: /Аймгийн сонгуулийн хороо/

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон 4 намаас 2 нам сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд ирүүлж, 2 нам нь зардлын тайлан гаргаж ирүүлээгүй байна.

Мөн 923 нэр дэвшигчээс 920 нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлангаа хуулийн хугацаанд ирүүлж, 3 нэр дэвшигч зардлын тайлан гаргаж ирүүлээгүй байна.

Орон нутгийн сонгуульд оролцсон 1 нам, 9 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй байна. Мөн 19 сумын Монгол ардын нам, Өмнөговь сумын Ардчилсан нам тусдаа зардлын данс нээгээгүй гэсэн тайлбараа албан бичгээр ирүүлсэн.

Бүлэг: 1

Орон нутгийн ИТХ-ын сонгуульд оролцсон 2 нам, 13 нэр дэвшигчдээс бусад нь Аймаг нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

1.1. Орон нутгийн сонгуульд оролцсон 1 нам, 9 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсэгт “Нам, эвсэл болон нэр дэвшигч нь сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг санал авах өдрөөс 20-оос доошгүй хоногийн өмнө төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасныг зөрчин орон нутгийн сонгуульд оролцсон 1 нам, 9 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлээгүй байна. /Хавсралт хүснэгт 2/

Дээрх зөрчлийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад зөвлөмж өгөв.

1.2. Сонгуулийн зардлын тайланг 2 нам, 3 нэр дэвшигч гаргаж ирүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3 дахь хэсэгт “Нам, эвсэл нь санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан, төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу 2 нам, 918 нэр дэвшигч хуульд заасан хугацаанд зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан ирүүлсэн байна.

Харин хуульд заасныг зөрчин 2 нам, 3 нэр дэвшигч зардлын тайлангаа гаргаж ирүүлээгүй байна. /Хавсралт хүснэгт 1/

Дээрх зөрчлийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад зөвлөмж өгөв.

1.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт заасан хандивын хэмжээг хэтрүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Мөнгөн хандив иргэний хувьд 2.0 сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд 10.0 сая төгрөг хүртэл байна” гэж заажээ.

Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд 2.0 сая төгрөгөөс дээш хэмжээний хандив өгсөн иргэн, 10.0 сая төгрөгөөс дээш хэмжээний хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

1.4 Сонгуулийн зардлын данс байршуулсан 4 банк сонгуулийн санал авах ажиллагаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор нам, эвсэл, нэр дэвшигчийн дансны гүйлгээний мэдээллийг ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5 дахь хэсэгт “Сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч уг дансны бүх гүйлгээний хуулгыг гаргаж, санал авах өдрөөс хойш 30 хоногийн дотор төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу нам, нэр дэвшигчдийн нээлгэсэн дансны хуулгыг ХААН банк, Төрийн банк, Голомт банк, Хас банкнууд гаргаж хуулийн хугацаанд гаргаж ирүүлсэн байна.

Бүлэг: 2 Сонгуулийн зардлын дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг 16 нэр дэвшигчээс бусад нь хуульд заасан зориулалтын дагуу зарцуулсан байна.

2.1. Нийт 16 нэр дэвшигч хуульд заасан шаардлагыг хангаагүй хандивыг зарцуулсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.4 дэх хэсэгт “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь нэр, иргэний бүртгэлийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ банкны гүйлгээний баримтад тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ” гэж заасныг зөрчиж 5.6 сая төгрөгийн мөнгөн хандивыг 16 нэр дэвшигч хүлээн авч зарцуулсан байна. /Хавсралт хүснэгт 3/

Дээрх зөрчлийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад зөвлөмж өгөв.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасан хандив өгөхийг хориглосон этгээдээс хандив хүлээн аваагүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Дараах этгээд хандив өгөхийг хориглоно” гэж заажээ. Үүнд:

- 55.1.1. Гадаад улс буюу гадаадын болон олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага;
- 55.1.2. Гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн;
- 55.1.3. 18 нас хүрээгүй хүн;
- 55.1.4. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд;
- 55.1.5. Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон албан татварын өр төлбөртэй, дампуурсан хуулийн этгээд;
- 55.1.6. Үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага;
- 55.1.7. Байгуулагдаад нэг жил болоогүй байгаа хуулийн этгээд гэж заажээ.

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид дээрх заалтыг зөрчөөгүй байна.

2.3. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлыг журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт “Сонгуулийн сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулна”, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/26 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайлан гаргах, зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам”-ын 14 дүгээр зүйлийн 14.2-д “Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлыг дараах байдлаар ангилж, тайлагнана” гэж ГНАГ-2024/12-ШТА-НА-УВА

заасны дагуу Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид сонгуулийн үйл ажиллагааны зардлыг дараах зориулалтаар нь зарцуулж, тайлагнасан байна. Үүнд:

- Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбай сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардал
- Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал
- Ухуулах байрны түрээсийн зардал
- Нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал
- Нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал
- Сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал
- Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах
- Сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардал
- Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал
- Энэ журмын 14.2.1-14.2.7-д хамаарахгүй бусад зардал

Бүлэг: 3

Сонгуулийн тойрогт нэр дэвшигч, нам эвсэл нь сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

3.1. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэгт “Сонгуулийн зардлын дансанд хуримтлагдах хөрөнгийн хэмжээнд тусгайлан хязгаар тогтоохгүй боловч тухайн сонгуулийн сурталчилгааны хугацаанд сонгуулийн зардлын данснаас зарцуулах зардлын хэмжээ нь энэ хуульд заасны дагуу тогтоосон сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтрэхгүй” гэж заасны дагуу нам, нэр дэвшигчид зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ” гэж заажээ.

Орон нутгийн ИТХ-ын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн нэрсийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

❖ **Намд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн:**

Орон нутгийн сонгуульд оролцсон 2 намд 4 иргэнээс нийт 7.0 сая төгрөгийн хандив өгсөн байна.

/Хүснэгт 2/

д/д	Аймаг сумын нэр	Намын нэр	Иргэнээс өгсөн мөнгөн хандив	
			Нэр	Дүн /мянган төгрөг/
1	Хяргас сум	Ардчилсан нам	Ж.Саруул	1,000.0
2	Увс аймаг	Монгол ардын нам	О.Сэндэгмаа	2,000.0
			Ж.Нацаг	2,000.0
			Л.Бадам	2,000.0
Дүн			4	7,000.0

Эх сурвалж: /Дансны хуулга/

❖ **Нэр дэвшигчдэд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, 2 сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээд:**

Орон нутгийн сонгуульд оролцсон 23 нэр дэвшигчид 35 иргэн, 3 хуулийн этгээдээс нийт 76.2 сая төгрөгийн хандив өгсөн байна.

/Хүснэгт 3/

д/д	Тойргийн дугаар	Нэр дэвшүүлсэн нам, эвслийн нэр	Нэр дэвшигчийн овог, нэр	Иргэн, хуулийн этгээдээс өгсөн мөнгөн хандив	
				Нэр	Дүн /мян.төг/
1	Завхан 4-р тойрог	Монгол ардын нам	Б.Пүрэвгончиг	П.Хүрэлсумъяа	1,000.0
2	Зүүнхангай 4-р тойрог	Монгол ардын нам	З.Пүрэвжаргал	Ц.Зулхүү	1,000.0
3	Увс аймаг 15-р тойрог	Ардчилсан нам	З.Түмэндалай	Н.Чимэдхүү	2,000.0
				З.Дэлгэр	2,000.0
				З.Жамбалдорж	1,000.0
4	Увс аймаг 29-р тойрог	Ардчилсан нам	Л.Банзрагч	Ж.Саруул	1,000.0
5	Увс аймаг 14-р тойрог	Ардчилсан нам	Б.Ганхуяг	Ж.Сурмаа	1,000.0
6	Увс аймаг 12-р тойрог	Ардчилсан нам	Б.Амарсанаа	Х.Бат-Амгалан	2,000.0
7	Увс аймаг 2-р тойрог	Монгол ардын нам	С.Батжаргал	Б.Солонго	5,000.0
8	Увс аймаг 15-р тойрог	Монгол ардын нам	Б.Норовсамбуу	Б.Ариунаа	2,000.0
				М.Ууганхүү	1,500.0
				Б.Далай	1,000.0
9	Увс аймаг 29-р тойрог	Монгол ардын нам	Л.Мөнхнаран	Увс хүнс ХХК	5,000.0
10	Увс аймаг 12-р тойрог	Монгол ардын нам	Э.Насанбат	Б.Нэргүй	3,000.0
11	Увс аймаг 25-р тойрог	Бие даагч	С.Пүрэвсүрэн	Зөв онош ХХК	5,000.0
12	Увс аймаг 15-р тойрог	Бие даагч	Ц.Батболд	Зөв онош ХХК	10,000.0
13	Увс аймаг 25-р тойрог	Бие даагч	Л.Сэнгэсамбуу	Лхагвасүрэн	1,000.0
				Түмэнд нээлттэй хязгаарынхан ХХК	5,000.0
				Сэнгэбаатар	1,000.0
14	Улаангом 3-р тойрог	Ардчилсан нам	Ш.Бат-Очир	О.Баттогтох	1,400.0
15	Увс аймаг 28-р тойрог	Монгол ардын нам	Б.Одсүрэн	И.Дамбасүх	1,300.0
16	Увс аймаг 18-р тойрог	Бие даагч	Д.Даваабаяр	Б.Дагвасүрэн	2,000.0
				Д.Отгонбаяр	2,000.0
				Н.Болд	1,000.0
				Д.Басанбаяр	2,000.0
				Ю.Бат-Орших	2,000.0
				С.Ичинноров	1,000.0
17	Улаангом 5-р тойрог	Монгол ардын нам	Х.Алтанхуяг	Л.Батхүү	1,000.0
18	Увс аймаг 18-р тойрог	Ардчилсан нам	Д.Цэндсүрэн	Ж.Цэвэлсүрэн	1,000.0
Д.Мөнхбат				1,000.0	
20	Увс аймаг 17-р тойрог	Бие даагч	Т.Алтанцэцэг	П.Рашаанжав	1,000.0
21	Увс аймаг 19-р тойрог	Бие даагч	О.Булган	С.Очируу	1,500.0
				О.Цэвээнгэрэл	1,000.0
22	Увс аймаг 15-р тойрог	Ардчилсан нам	Ц.Балдорж	Ч.Жаргал	1,500.0
				Н.Цэдэнбалжир	2,000.0
				Ц.Бат-Эрдэнэ	1,000.0

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

23	Увс аймаг 26-р тойрог	Ардчилсан нам	Н.Шинэхүү	Ж.Цэзэн	1,000.0
				Н.Мөнгөншагай	1,000.0
Дүн			23	38	76,200.0

Эх сурвалж: /Дансны хуулга/

3.2 Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид мөнгөн бус хандив аваагүй байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт "Мөнгөн бус хандивт дараах зүйл хамаарна"

54.1.1. Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх;

54.1.2. Үйлчилгээ үзүүлэх.

54.2. Мөнгөн бус хандивыг сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид өгнө.

54.3. Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хандивын гэрээг бичгээр байгуулж гэрээнд заасан зориулалтын дагуу зарцуулна.

54.4. Мөнгөн бус хандивын үнэлгээг зах зээлийн дундаж ханшийг үндэслэн хандивын гэрээгээр тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна гэж заажээ.

Орон нутгийн сонгуульд оролцсон нэм, нэр дэвшигчид мөнгөн бус хандив аваагүй байна.

Дүгнэлт

Нийцлийн аудитын явцад олж цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаанд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Орон нутгийн сонгуульд оролцсон 1 нам, 9 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны дугаар, банкны нэрийг бүртгүүлээгүй байна.
2. Сонгуулийн зардлын тайланг 2 нам, 3 нэр дэвшигч гаргаж ирүүлээгүй байна.
3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хандивын хэмжээг хэтрүүлээгүй байна.
4. Арилжааны банкууд орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчдийн нээлгэсэн дансны хуулгыг хуулийн хугацаанд гаргаж ирүүлсэн байна.
5. 16 нэр дэвшигч нь нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээллээ тусгаагүй 5.6 сая төгрөгийн хандивыг буцаан шилжүүлэхгүйгээр зарцуулсан байна.
6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд заасан хандив өгөхийг хориглосон этгээдээс хандив хүлээн аваагүй байна.
7. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид сонгуулийн зардлыг журмын дагуу зарцуулж, тайлагнасан байна.
8. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид хуулийн дагуу тогтоосон зардлын дээд хэмжээг хэтрүүлээгүй байна.
9. Орон нутгийн сонгуульд оролцсон 2 намд 4 иргэнээс нийт 7.0 сая, 23 нэр дэвшигчдэд 35 иргэн, 3 хуулийн этгээдээс нийт 76.2 сая төгрөгийн нэг сая ба хоёр сая, түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн байна.
10. Орон нутгийн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид мөнгөн бус хандив аваагүй байна.

Зөвлөмж

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Б.Эрдэнэсүрэн, Татварын газрын дарга М.Галсүрэн нарт:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн нам, нэр дэвшигчдэд Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд заасны дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах.

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:
АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ



/ М.БАТ-АМГАЛАН /

/ Б.АВИРМЭД /

/ Р.АЮУШ /